



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“Хархорин АЗЗА” ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан

Аудитын код: **ӨВА-2023/03/НА-СТА-ТӨА**

<p>Цахим хуудас: www.audit.mn Өвөрхангай аймаг, Арвайхээр сум 2023 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: О.Батжаргал Утас: 70323253 Цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn Аудитын менежер: Д.Гансүх Утас: 70323833 Цахим хаяг: gansukh.audit@gmail.com Ахлах аудитор: Б.Эрдэнэцэцэг Утас: 70323108 Цахим хаяг: Erdenetsetsegb@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гандангийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 60173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: ovorkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2023.03.10 № 144
Танай _____ -ны № _____ -т

ХАРХОРИН АЗЗА ТӨХК-ИЙН
ЗАХИРАЛ Ч.АЛТАНБАГАНА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хархорин АЗЗА ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Өвөрхангай АЗЗА ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Тайлант онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 307-р тогтоолоор 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийн цэвэр ашгийн дүнгээс Ирээдүйн өв санд төвлөрүүлэх төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг 20.9 сая төгрөгийг Сангийн яаманд төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Тус компани нь тайлант онд 2,293.3 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллажээ. НӨАТ-ын тайлангаар 11.6 сая төгрөгөөр орлого дутуу тайлагнасан байсанд залруулга хийсэн. Зориулалт бус зарцуулалттай холбоотой 5.3 сая төгрөг, урт хугацаат өр төлбөрийг барагдуулаагүй, кассаар гарсан зарцуулалтын анхан шатны баримтыг И-баримтаар баталгаажуулаагүй байсан зэрэг зөрчил дутагдлууд байна. Бусад мэдээллийн талаар онцлог анхаарал татсан зүйлгүй байна

015030648

**“Хархорин АЗЗА” ТӨХК-ийн
2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



О. БАТЖАРГАЛ

"Хархорин АЗЗА" ТӨХК-ийн
2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.1. Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгө	428,714,996.11	229,199,489.73
1.1.2. Дансны авлага	0.01	13,118,539.01
1.1.6. Бара материал	196,479,769.10	339,129,507.44
1.1.11. Эргэлтийн хөрөнгийн дүн	625,194,765.22	581,447,536.19
1.2.1 Үндсэн хөрөнгө	927,487,035.75	1,011,472,633.45
1.2.2 Биет бус хөрөнгө	260,302,000.00	261,369,200.00
1.2.12 Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,187,789,035.75	1,272,841,833.45
1.3 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,812,983,800.98	1,854,289,369.64
2.1.1.1 Дансны өглөг	0.00	-0.02
2.1.1.3 Татварын өр	44,163,103.83	73,478,712.96
2.1.1.4 НДШ-ийн өр	11,274,877.89	438,287.20
2.1.1.13 Богино хугацаат өр төлбөрийн дүн	55,437,981.71	73,917,000.13
2.1.2.4 Бусад урт хугацаат өр төлбөр	227,624,928.00	227,624,928.00
2.1.2.6 Урт хугацаат өр төлбөрийн дүн	227,624,928.00	227,624,928.00
2.2 Өр төлбөрийн нийт дүн	283,062,909.71	301,541,928.13
2.3 Эздийн өмч	743,765,952.91	743,765,952.91
2.3.1 Терийн	743,765,952.91	743,765,952.91
2.3.6 Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	243,622,677.14	243,622,677.14
2.3.9 Хуримтлагдсан ашиг	542,532,261.21	565,358,811.45
Өмнөх	542,532,261.22	521,632,261.22
Тайлант үе	-0.01	43,726,550.23
2.3.11 Эздийн өмчийн дүн	1,529,920,891.26	1,552,747,441.50
2.4 ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,812,983,800.98	1,854,289,369.64

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Үзүүлэлт	Өмнөх үеийн дүн	Тайлант хугацаа
1. Борлуулалтын орлого(Цэвэр орлого)	2,453,414,128.63	2,293,310,834.25
2. Борлуулсан бүтээгдэхүүний өртөгг	2,093,843,476.03	1,887,604,922.98
3. Нийт ашиг (алдагдал)	359,570,652.60	405,705,911.27
8. Бусад орлого		
9. Борлуулалт, маркетингийн зардал		
10. Ерөнхий ба удирдлагын зардал	264,220,113.11	291,956,209.45
11. Санхүүгийн зардал		
12. Бусад зардал	48,882,557.71	65,164,646.00
17. Бусад ашиг (алдагдал)		
18. Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	46,467,981.77	48,585,055.82
19. Орлогын татварын зардал	4,646,798.17	4,858,505.58
20. Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг	41,821,183.60	43,726,550.24
21. Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах		
22. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	41,821,183.60	43,726,550.24
23. Бусад дэлгэрэнгүй орлого		
24. Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	41,821,183.60	43,726,550.24
25. Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

"Хархорин АЗЗА" ТӨХК-ийн
2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	732,165,952.91	243,622,677.14	542,532,261.21	1,518,320,891.26
2	Дахин інэлгээний нэмэгдэлийн				
3	2022 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	743,765,952.91	243,622,677.14	542,532,261.21	1,529,920,891.26
4	Нягтлан бодох біртгэлийн бодлогын				
5	Залруулсан ілдэгдэл				
6	Тайлант іеийн цэвэр ашиг (алдагдал)			43,726,550.24	43,726,550.24
7	Бусад дэлгэрэнгій орлого				
8	Өмчид гарсан өөрчлөлт			-20,900,000.00	-20,900,000.00
9	Зарласан ногдол ашиг				
10	Дахин інэлгээний нэмэгдэлийн				
11	2023 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	743,765,952.91	243,622,677.14	565,358,811.45	1,552,747,441.50

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

	Үзүүлэлтийн нэр	Өмнөх үеийн дүн	Тайлант хугацаа
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	2,819,015,530.06	2,711,268,689.50
1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		
	Эрхийн шимтгэл, хураамж, телберийн орлого		
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхїїжилтийн орлого		
	Бусад мөнгөн орлого	2,819,015,530.06	2,711,268,689.50
1.2	1.2 Мөнгөн зарлагын дїн	2,587,393,657.43	2,910,784,195.88
	Ажиллагчдад төлсөн	412,985,671.00	418,052,276.00
	Нийгмийн даатгалын байгуулгад төлсөн	127,153,490.79	157,373,742.74
	Бараа материал худалдан авахад төлсөн	1,821,349,696.65	1,995,633,943.26
	Татварын байгуулгад төлсөн	165,369,798.99	127,225,033.88
	Бусад мөнгөн зарлага	60,535,000.00	212,499,200.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	231,621,872.63	199,515,506.38
2	2.Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн +		
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.2	Мөнгөн зарлагын дүн -		
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.3	2.20 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр		
3	3.Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн +		
	Зээл авсан ерийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.2	Мөнгөн зарлагын дүн -		
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөртөлсөн мөнгө		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн	231,621,872.63	199,515,506.38
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	231,621,872.63	199,515,506.38
5	Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	197,093,123.48	428,714,996.11
6	Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	428,714,996.11	229,199,489.73

**"Хархорин АЗЗА" ТӨХК-ийн
2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

д/д	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2021 оны гүйцэтгэл	2022 он		харьцуулсан хувь	
				төлөвлөгөө	гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Бүтээгдхүүн үйлдвэрлэл	м.төг	2,453,414.10	2,350,000.0	2,293,310.80	97.6	(56,689.20)
	Улсын чанартай зам засвар арчлалтын ажил	м.төг	1,868,708.70	2,000,000.0	1,915,326.30	95.8	(84,673.70)
	Орон нутгийн чанартай зам засвар арчлалтын ажил	м.төг	584,705.40	350,000.0	377,984.50	108.0	27,984.50
2	Нийт орлого	м.төг	2,453,414.10	2,350,000.0	2,293,310.80	97.6	(56,689.20)
3	Нийт зардал	м.төг	2,406,946.20	2,303,000.0	2,244,725.70	97.5	(58,274.30)
4	Татварын өмнөх ашиг	м.төг	46,467.90	47,000.0	48,585.10	103.4	1,585.10
5	Цэвэр ашиг /алдагдал/	м.төг	41,821.20	42,300.0	43,726.50	103.4	1,426.50
6	Төсвийн нийт төлбөр	м.төг	360,624.10	380,726.6	350,518.10	92.1	(30,208.50)
7	ашиг	м.төг	4,449.50	4,230.0	20,900.00	494.1	16,670.00
8	Орлогын татварт	м.төг	4,646.80	4,700.0	4,858.50	103.4	158.50
9	Авлага	м.төг	0.00	9,000.0	13,118.50	145.8	4,118.50
10	Нийт өглөгө	м.төг	283,062.80	235,624.9	301,541.90	128.0	65,917.00
	Богино хугацаат өр	м.төг	55,437.90	8,000.0	73,917.00	924.0	65,917.00
	Урт хугацаат зээл	м.төг	227,624.90	227,624.90	227,624.90	100.0	-
11	Борлуулалтын орлогын нэг төгрөгт ноогдох	төг	0.98	0.98	0.97	99.0	(0.01)
12	Хөрөнгө оруулалт	м.төг	84,600.00	258,619.80	205,763.20	79.6	(52,856.60)
13	Нийт цалингийн сан	м.төг	490,218.50	485,856.0	499,331.00	102.8	13,475.00

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 11.6 сая төгрөгийн алдаа¹ илэрч аудитын явцад залруулсан.

Үүнд: /Орлогын дэлгэрэнгүй тайлангийн борлуулалтын орлого, НӨАТ-ын тайлангийн орлого 11615.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан байна. Энэхүү залруулсан НББ-ийн алдаа нь нийт буруу илэрхийллийн дүнд орохгүй/

Аудитаар нийт 270.2 сая төгрөгийн зөрчил² илэрснээс 5.3 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 264.8 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Тус байгууллагад акт гараагүй.

5.2 Албан шаардлага

- Дарга, инженер, менежер, нягтлан бодогч, даамал нарын гар утасны ярианы төлбөрт 4351.1 мянган төгрөг зарцуулсан
- Баруун хүрээ хийдэд хамт олноороо ном хуруулах арга хэмжээнд 975.0 мянган төгрөг зарцуулсан байсанд зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

"Хархорин АЗЗА" ТӨХК-ийн
2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

1. Өглөгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Куветын сангийн хөрөнгөөр ирсэн 227624.9 мянган төгрөгийн машин техник хэрэгслийг 2009 онд урт хугацаат өр төлбөрөөр бүртгэсэн ч өнөөг хүртэл барагдуулаагүй, хэрхэн шийдвэрлэх нь тодорхой бус байна.

Өгсөн зөвлөмж:

Зөвлөмж-1: Урт хугацаат өр төлбөрийг барагдуулах асуудлыг ТӨБЗГ-т тавьж шийдвэрлүүлэх.

2. Кассын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Кассын данснаас бараа материал худалдан авахдаа 37188.0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгслийг НӨАТ-ын баримтаар давхар баталгаажуулаагүй. Мөн Е-баримт шивэгдсэн ч НӨАТ төлөгч биш байгууллагаас худалдан авалт хийсэн тохиолдол түгээмэл байгаа нь тус компанийн НӨАТ-ын өр үүсэхэд тодорхой хэмжээгээр нөлөөлж байна.

Өгсөн зөвлөмж:

Зөвлөмж-2: Бэлэн мөнгөөр худалдан авалт хийхээс аль болох зайлсхийж, НӨАТ төлөгч ААНБ, хувь хүнээс худалдан авалт хийхэд анхаарч ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орлого дутуу тайлагнасан.	1	11.6					1	11.6				
Дүн	1	11.6					1	11.6				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нэгжний зардал гаргасан	1	4.3			1	4.3						
Зориулалт бус зарцуулсан	1	1.0			1	1.0						
Өглөг барагдуулаагүй	1	227.6					1	227.6				
Дүн	3	232.9			2	5.3	1	227.6				

“Хархорин АЗЗА” ТӨХК-ийн
2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 11